

► Токарчин

Улаанбаатар хот
Ажлын байрны код: MST1118

Хойд Америкт төдийгүй олон улс дахь Комацу-гийн томоохон борлуулагч компаниудын нэг СМС Экьюпмэнт корпорацийн салбар компани болох Трансвест Монголиа ХХК нь үйлчлүүлэгчдийнхээ онцлогт тусгайлан тохируулсан содон шийдлүүдийг гаргаж өгдөг уул уурхайн чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээ, тоног төхөөрөмж нийлүүлдэг тэргүүлэгч компани юм.

*Бид Улаанбаатар дахь Засвар үйлчилгээний газарт **Токарчин** шалгаруулж авна.*

Гүйцэтгэх үндсэн үүрэг:

Гагнуурын цехийн мастерийн шууд удирдлаганд дараах үндсэн үүрэгтэй ажиллана. Үүнд:

- Аюулгүй ажиллагааны арга барилыг мөрдлөг болгон манлайлж ажиллах;
- Компанийн төлөөлөл болохын хувьд хариуцлагатай байх;
- Өдөр тутмын засвар, үйлчилгээ, даалгасан үүрэг даалгаварыг үйлдвэрлэгчээс гаргасан стандарт, журмын дагуу цаг хугацаанд нь үр дүнтэй гүйцэтгэх;
- Ажлын чанарт хяналт тавих;
- Үйлчлүүлэгчид төвлөрсөн зарчим болон харилцан уялдааг дэмжиж ажилладаг байх;
- Ажлын ирц, оролцоог дээд зэргээр хангах;
- Гар багажуудыг байнга зөв, зохистой хэрэглэх;
- Засварын цехийн мастерын даалгасан бусад ажил үүргийг гүйцэтгэх зэрэг болно.

Тавигдах шаардлага:

- Мэргэжлийн үнэмлэхтэй байх;
- Хүнд даацын тоног төхөөрөмжийн эд ангиуд дээр ажиллаж байсан туршлагатай;
- Цаг баримталдаг, аюулгүй ажиллагааны дүрэм журмыг нягт биелүүлдэг байх;

Сонирхсон хүмүүс ажилд орох хүсэлтээ хувийн намтрын хамт **2018 оны 12 дугаар сарын 01-ний** өдрийн 17:00 цагаас өмнө careers@transwest.mn хаягаар илгээнэ үү.

Трансвест Монголиа ХХК нь хүсэлт гаргасан та бүхэнд талархал илэрхийлэхийн зэрэгцээ зөвхөн сонгогдсон хүмүүсийг дараагийн шатны шалгаруулалтад оролцуулахыг мэдэгдэж байна.

Трансвест Монголиа ХХК тамхигүй орчныг дэмждэг.

